



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/05

Бор-Өндөр

Соёлын төвийн бүтэц орон тоог
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт “Соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалт”, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвсийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайдын 2011 оны 83 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Сумын соёлын төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 10 дугаар заалт -ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бор-Өндөр сумын Соёлын төвийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц орон тооны дагуу үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллахыг Соёлын төвийн дарга (М.Чулуунцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ

Бор-Өндөр сумын Засаг даргын
2025 оны 01 сарын 09 өдрийн
1/05 тоот захирамжийн хавсралт



Соёлын төвийн бүтэц, орон тоо

№	Орон тоо	Мэргэжилтний тоо
1	Дарга	1
2	Номын санч	1
3	Хөгжмийн багш	1
4	Бүжгийн багш	1
5	Орон нутаг сурталчилах танхимын ажилтан	1
6	Техникч	1
7	Үйлчлэгч	1
Нийт		7